



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар Д/64

Чингис хот


Хорин хоёр нь юс" хэвлэл мэдээллийн
хэрэгсэлтэй хамтран ажиллахад хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сумын хэмжээнд хийгдэж буй ажил, арга хэмжээг олон нийтэд ил тод, шуурхай мэдээллэх, ард иргэдийг мэдээллээр хангах зорилгоор "Хорин хоёр нь юс" хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллахад зарцуулагдах зардлыг баталсугай

2.Дээрх зардалд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэх зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР